



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 1174

Шивээговь сум

Аж ахуйн нэгжийн тооллого явуулах
 комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.г, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн "з", 20 дугаар зүйлийн 20.2, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 дугаар "Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын аж ахуйн нэгжийн 2021 оны улсын тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

О.Даваажав (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд:

Н.Амаржаргал (1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар (2 дугаар багийн Засаг дарга)

Л.Алдар (Улсын бүртгэгч)

Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Б.Мөнхцэцэг (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Буяндэлгэр (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Э.Төрмандах (Соёлын төвийн дарга)

2. Тооллогыг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохих журмын дагуу чанартай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ

П.ГАНЧИМЭГ